

Монгол гар урлалын бүтээлч уламжлал: онцлог байдал

Б.Наянтай

ӨМӨЗО, Отогийн өмнөд хошууны ажил мэргэлийн дээд сургууль

Хураангуй

Гар урлалын мэргэжил бол хүмүүн төрөлхтний амьдрал үйлдвэрлэлийн дагуу үүсэн бүрэлдэж, алхам алхмаар боловсрон төгөлдөржиж өнөөгийн нийгмийн шат үед тэвшин уламжлагдаж ирсэн эд ба оюуны соёлын дутагдаж болшгүй чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Тэр нь хэзээд хүмүүсийн амьдрал үйлийн бүх талд нэвчсэн түгээмэл соёлын илэрхийлэл байж, нийгэм даяар маш өг соёлын ба хэрэглээний хүртээлтэй байдаг. Энд монголчуудын өнгөрсөнд оршин амьдарч байсан ахуй орчноор жишээлбэл: онгон байгальтайгаа шүтэлцсэн монгол гэртээ амьдрах, өлзий бэлгэт гал голомтоо бадрааж, таван хошуу малынхаа буян хишгийг хүртэн, өдөр болгоны ургах нарантай зэрэгцэн амьдралаа өрнүүлэхэд ач түшгээ өгсөн модон аяга (мөнгөн аяга), модон шанага, модон таваг, модон ширээ, модон суулга, модон огооро, модон эмээл, модон уурга, модон араг, модон тэргээс эхлүүлээд аль бүхэнд нь ажилч хүмүүний ур ухааныг амилуулсан дархан бүтээлүүд байдаг. Гар урлалын бүтээл нь ихэвчлэн мод, яс, чулуу, төмөрлөг, арьс зэрэг бэлэн зүйлсээр урлах материал болгож, хүний хүчээр урлан бүтээхээр голлодог. Түүнийг хүний амьдралын хэрэгцээг хангах ба амьдралыг гоёлон чимэглэхээр зорилго болгож, түүнд зориулагдсан олон төрлийн эдлэлийг урлан бүтээдэг учир урлан бүтээх арга барил нь ч олон зүйлийн байдаг. Бөс арьсны зүйлийг урлан бүтээхэд эсгэх, хайчлах, оёх, хатгамаллах аргыг хэрэглэдэг. Чулуугаар урлан бүтээхэд цохиж хэлтлэх, үрж билүүдэх, цавчиж нүхлэх, сийлж сийлбэрлэх аргыг хэрэглэдэг.

Түлхүүр үг

Гар урлал, мод, яс, чулуу, төмөрлөг, арьс, соёл, уламжлалт соёл, монгол ахуй, нүүдэлчин соёл

Удиртгал

Ус, агаар, нарны гэрэлгүй бол өг дулаан дэлхий ертөнц байхгүйтэй адилаар өгөөмөр ачит байгаль ээж байхгүй бол үй түмэн хүмүүн амьтан ч оршин тогтнож чадахгүй билээ. Хүмүүн төрөлхтөн бол байгаль ертөнцийн бүтээл болох мөртөө “хүмүүний бие сэтгэлийн гоо сайхан нь байгалийн хэрэг бодис хөгжөөд хамгийн дээд шатанд хүрсэн үеийн гоо сайхан болсон тул байгаль ертөнцөд үүссэн ‘хамгийн гоё цэцэг’ болох ёстой”. Хүн төрөлхтөн манай одоогийн дэлхий ертөнцөд бий болсноос эхлээд өнөө болтол хөгжиж ирэхдээ урт удаан түүхийн хугацааны туршид тоолшгүй баялаг оюуны болон эдийн соёл боловсролын үүдэн бүтээсний дотор гар урлал бол хамгийн анхны бөгөөд голлох байр суурийг эзлэх эд ба оюуны соёлын хөгжлийн гени ерөнхий тусгал болдог. Иймээс гар урлалын үүсэл түүхийг нарийвчлан судлах нь хүмүүн төрөлхтний адил бус хөгжлийн үе шат дахь шүтлэг бишрэл, зан үйл, хүсэл мөрөөдлийг ойлгоход хамгаас найдвартай гар хавсрагч нь болдог. Ардынхаа гар урлалын хөгжлийн зүй тогтлыг судалж, шинжлэхүй ухааны үүднээс учрыг олж, хужрыг тунгааж шинжлэн магадлах явдал урлахуй ухааны мэргэжилтэй газар газрын монгол иргэн, монголч эрдэмтэн бидний сэгээ самбаа мэдэх хэрэг, зориг сэдлийн учир утга билээ (Батчулуун, 1999, х.20, 21). Аргын ёсон төрүүлмөй, билгийн ёсон бүтмөй. Арга билиг нь

нийлэлдвээс хамаг бүгдийг төрүүлмөй. Үүнээс эс гарах, эс бүтээх нэгээхэн буур үгүй тул ийнхүү бас хоёргүй номын хаалга хэмээмүй (Дандаа. 68.56) гэж эрдэнэт толь шашдиртаа шинжлэн бичсэнчлэн ардынхаа урлахуй ухааны эл гайхамшигт төрлийг судалж, түмэн олондоо толилохдоо эд өлөг, утга соёлын төрөл бүрийн дурсгалыг онол дадлагын аль ч талаар харшуулан үзэж, задлан шинжилж нэгтгэн дүгнэхийг зорьсон билээ. Хүн төрөлхтөн нийгмийн өндөрлөгт хурах үед өөрчлөгдсөн үеийг эртний хөгжилтэй хамруулан түүхийн нөөц хуримтлуульж хөгжиж дахин цааш эзэмшин, хэлбэрт нь эрчимтэй хөгждөг болохыг эрдэмтдийн онолын судалгаа харууллаа. Монголчууд бол дэлхий дахинд алдаршсан өвөрмөц соёл боловсролтой эртний боловсон үндэстний нэг болно. Шинэ чулуун зэвсгийн эхний үеэс Монголын өндөрлөгт орших анчин нүүдэлчин аймгууд нь анх ан гөрөө хийх, үр тариа тарих, гэрийн тэжээвэр амьтан дасгах мэт үйлдвэрлэлийн төрөл зүйлийг хамтатган эрхэлж байснаа урт хугацааны хөгжлийн үрдүнд, Монголын өндөрлөгийн эх байгалийн улирал хувирлын жим ёсонд нийцсэн нүүдлийн мал аж ахуйг сонгож, өөрсдийнхөө тулгуур аж ахуйгаа болгосон байдаг. Монголын өндөрлөгт суурьшсан эртний хүмүүсийн гар урлалын соёл үүсэн бүрэлдсэн түүх нь хуучин чулуун зэвсгийн дунд үед холбогдох бөгөөд эртний Монголчуудын гар урлал нь тэдний тухайн үеийн

орчин тойрны уур амьсгал, газрын байц хийгээд гол эрхлэн хийж байгаа аж ахуйн төрөл хэлбэртэй нь шууд хамаарагддаг байв. Хүмүүн юуны урьдаар ямар нэгэн зүйлийг хийж бүтээе гэсэн санаа хүсэлтэй болоход үйл ажиллагааны явцдаа бодитой онолын ба үйлдлэгийн арга туршлагатай болдог. Нүүдэлчдийн урлагийн нэгэн содон онцлог гэвэл уран бүтээлдээ нэр тавьдаггүй бөгөөд ялангуяа хэзээ ч урлалыг өмчилж нэрлэж байсангүй, уламжлалт ёс заншлаа өвлөсөн монголын соёлд тэгэх хэрэгцээ ч гараагүй юм (Батчулуун, 1999, х.23).

Монгол ардын гар урлалын бүтээлийн ангилал

Гар урлалын бүтээлийн олон шинж тэмдгээс тохиолдлын чанартай биш, хамгийн түгээмэл нөхцөл байдлуудаар нь харьцуулж, төрлөөр бүлэглэх арга их чухал байдаг. Ардын урлалыг ангилахад баримтлах үндсэн нөхцөл бол урлах материал буюу юугаар бүтээсэн вэ? гэдэгт байна. Гар урлалын олон төрөл зүйл, урлах арга ухаан, материал хэрэглэгдэхүүн цөм харилцан нөлөөлж, ардын гар урлалын зарчмыг бий болгожээ. Монголын нүүдлийн мал аж ахуй амьдралын хэв шинжийн хувьд урлагт голлох байдлаар нөлөөлж иржээ. Малаас гарах ноос, ноолуур, арьс шир, яс, эвэр нь гар урлалын олон төрөлд гол материал болсоор иржээ. Мөн байгалийн баялаг болох мод, чулуу, шавар нь шаазан урлалын гол материал болно. Алт, мөнгө, зэс, гууль, ган, төмөр зэрэг төмөрлөг урлалын гайхам сайхан материал болно. (Ядамжав.Ц.2004. х-17) Ардын гар урлалын хийх материал /төмөр, мод, эрдэс чулуулаг, арьс шир, эсгий ноос гэх мэт/ цаглашгүй урлах арга /оёх, хатгах, нэхэх, наах, сийлэх, цоолох, зүмбэрлэх, гуух, барих, зурах, урлах гэх мэт/ олон талтай ч тэдгээрийг нэгэн санаанд нэгтгэж, тодорхой үүрэг зорилгод чиглүүлж, материалын боловсруулалт, ур хийцийн зохицлыг олсноор ардын урлалын чуулга шинж билээ. Материалыг оновчтой төгс боловсруулдаг чадал, юмны донж маяг, галбир, төрх байдлыг гайхалтай илэрхийлсэн хэлбэр, уран санааг бодитой зохицуулж, зөн билэгдлийг ончтой илэрхийлсэн зохиомж, өнгө гэрлийн харьцаа, тэдгээрийн зохирол эрэмбэ, харилцан шилжилтийн ухааныг үнэхээр нэвтэрхий шийдсэн нь ардын гар урлалын ололт нээлт билээ. Монгол урчууд зааны яс эрдэнийн чулууг сийлээд зогсоогүй ган төмрийг сийлж, цоолж, ахуй амьдралын хэрэгцээт зүйлээс ардын урлагийн бие даасан бүтээл хүртэл туурвисаар иржээ. Зэс төмрийг давтаж, бурхны дүр, номын хуудсыг сийлсэн Жамбын бар, мөнгөн хуудсыг хөөж үсгээ товойлгоод шүтээний алтан ингэмэл дүрийг товойлгон сийлсэн Сандуйнжүд ном Монгол улсын төв номын санд хадгалдагдаж байна. Таван зуун хуудас бүхий Жадамбын зэс

барыг хүрээний уран дархан Минжүүр толгойлж бүтээсэн бол мянга дөрвөн зуун жаран лан алт мөнгө холин цутгаж, давтаж, сийлж, зандан модоор хүрээлсэн зуун арван нэгэн хуудас бүхий Сандуйнжүдийг дархан Намжилдагва тэргүүлэн бүтээжээ. Ган төмрийг хатаан ширээж ангийн буу, хэт хутга, эмээлийн дөрөө, аяганы хайрцаг, шүтээний хэрэгсэл зэрэг олон зүйлийг урлаж байжээ. Ган төмрийг мод шиг сийлж байснаас гадна мөнгөн утсыг мяндас торгон утас шиг сүлжиж, дуртай урлалаа хийдэг байжээ. Тэр ч байтугай хөлгөн их судрыг алтаар буюу есөн эрдэнээр бичиж байлаа. Эр хүний хэт хутгаас эмээлийн баавар даруулга, хазаарын мөнгөн ороолт, аяга хүртэл зүйл зүйлийн эдлэл хэрэглэл алт мөнгөний урлал багтана. (Лувсанвандан, 1982, х.52)

Гар урлалыг ангилахад дээрх бэлэн материалыг урлагийн бүтээл болгох арга чухал байр эзэлнэ. Мод чулууг сийлнэ. Алт мөнгийг хайлна, цутгана, хөөмөлдөнө. Ноосоор эсгий хийнэ, утас ээрнэ, дээс томно. Арьс шир ч өөрийн боловсруулах арга технологитой байдаг. Энэ бүхнээс үндэслээд монгол үндэстний гар урлалын төрлүүд урлах арга барил, материалын байдлаас хамаарсан олон зүйлтэй байдгийг нотолгоо энэ болно.

Манай ардын урлаг бол сийлбэр, хатгамал, алт мөнгөн урлаг, наамал, шуумал, будаг, цоолбор гэх мэтийн материалын дагуу тус бүрдээ мэргэжсэн урчуудтай урлаг юм. Энэ урлаг нь тус бүрдээ хийх аргаар өвөрмөц боловч түүний хэлбэр маяг, зураг, хэмжээ, харьцаа, гоёл чимэглэлийг нь тохируулах нь адил билээ. Жишээ нь, сийлбэрч хүн бол ганцхан материал сийлж чаддагтаа сийлбэрчин болж чадахгүй. Харин хийх зүйлийнхээ зураг эскизийг хийх чадварыг дүүрэн эзэмшсэн, түүний хэв хэлбэр, анатоми, хэмжээ, хөдөлгөөнийг бүрэн мэддэг байх ба үүний тохирсон багаж хэрэглэлийг цаг тухайд нь хийж чаддаг бүтээлийнхээ их биений, мужааны ажлыг хийж чадах мужааны мэдлэг дадлагатай байх хэрэгтэй байдаг (Гэвшээхүү, 1970, х.5).

Гар урлалыг хэрэглээний гар урлал ба үзмэрийн гар урлал гэж хоёр төрөл байдаг. Үзмэрийн гар урлал бол хүмүүсийн үзэж сонирхох ба орчин тойрноо гоёлон чимэхэд зориулагдсан уран бүтээл болно. Бидэнд үргэлж харагддаг зааны соёоны сийлмэл, хас чулуун сийлмэл, модон үндсийн сийлмэл, шаазангийн уран бүтээл зэрэг бол үзмэрийн гар урлалдаа тооцогдоно. Хэрэглээний гар урлал бол уран дүрслэг шинжийг хадгалсан хүмүүсийн амьдрал үйлдвэрлэлийн хэрэглээний бодсын бүтээгдэхүүн болно. Түүнд орон барилга, хувцас өмсгөл, засал зэмсэг, өдөр тутмын хэрэглээний зүйлс багтана. Гар урлалын бүтээлийн хамгийн гол онцлог нь зөвхөн тэр ястан үндэстний гоо сайхны мэдрэмж, үзэл таашаалыг өөртөө хадгалсан, тухайлсан нэг хүний ур чадвар

арга барилын давтагдашгүй өвөрмөц биелэл байдагт оршино. Уран хүний өөрийн гараар бүтээсэн нэг содон бүтээл, урлал, үйлдвэрлэлийн өндөр технологиор боловсруулж, бөөнөөр үйлдвэрлэсэн ямар ч бүтээгдэхүүнээс илүүгээр хүмүүсийн сонирхол татан үнэлэгддэгийн учир нь чухамдаа тэр дахин давтагдашгүй өвөрмөц олон шинжийг агуулдагт оршдог (Ядамжав, 2004, х.15).

Монголчууд амьдрал үйлдвэрлэлийн өдөр тутмын эд хэрэглээ болох нум сум, хувцас хунар, цөгц цоолтуур, ногт чөдөр, эмээл, дөрөө, ваар сав, гэр орц зэргээ төхөөрөн үүдэх хөдөлмөрийнхөө дагууд хамаг эртний “гар урлал”-гийн соёлын өвөрмөц хэв загварыг үүдэн бүтээж цогц бүтээсэн нотлох баримтууд байдаг. Жишээлбэл, шинэ чулуун зэвсгийн үеийн анхны урлагийн төрөл зүйл болох хээ угалзтай ваар сав хийх, хад чулуун дээр янгир, аргаль, бар ирвэс, буга согоо, адуу үхэр мэт амьтныг зурж сийлэх ажиллагаа нь Монголын өндөрлөгт нийгэм явагдаж байжээ. 1975 онд Өвөр Монголын Огниуд хошуунаас олсон ногоон хасаар сийлсэн луугийн сийлмэл нь дотоод, гадаадад их алдартай билээ. Үүнээс манай орны эртний хүмүүн төрөлхтөн таван мянга гаруй оны өмнө хас урлал хийж байсан гэдгийг нотолж байна. Үүнд, монгол адууг гаршуулан бойжуулж, монгол гэрийг үүдэн бүтээсэн үүдэлт бол монгол хүмүүний цэцэн мэргэн ой билиг, гарамгай уран ур чадлын төлөөлөгч бүтээл болох ёстой. Монголчуудын гар урлал бол Монгол үндэстний түүхэн хөгжилтийн явцад бүрэлдэн тогтсон бүхий л эд оюуны соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Гар урлалын соёл нь монголчуудын уламжлалт шинжлэх ухаан соёл боловсролын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсны хувьд балар эртний үеэс Монгол хаант улс болтол, Юань, Мин, Чингийн үеэс өдгөө болтол тасралтгүй өөдлөн бадрах амьд хүчээ хадгалсаар ирсэн бөгөөд тэр нь хүний амьдралын хэрэгцээг хангахаас гадна бас гоо сайхны хэрэгцээг хангадаг.

Гар урлалын бүтээл нь ихэвчлэн мод, яс, чулуу, төмөрлөг, арьс зэрэг бэлэн зүйлсээр урлах материал болгож, хүний хүчээр урлан бүтээхээр голлодог. Түүнийг хүмүүсийн амьдралын хэрэгцээг хангах ба гоёл чимэглэлд зориулагдсан олон төрлийн эдлэлийг урлан бүтээдэг учир урлан бүтээх арга барил нь ч олон зүйл байдаг. Бөс арьсны зүйлийг урлан бүтээхэд эсгэх, хайчлах, оёх, хатгамаллах аргыг хэрэглэдэг. Чулууны зүйлийг урлан бүтээхэд цохиж хэлтлэх, үрж билүүдэх, цавчиж нүхлэх, сийлж сийлбэрлэх аргыг хэрэглэдэг. Модон эдлэлийг урлахад сүлжих, онгилох, шулах, сийлэх зэрэг аргыг хэрэглэдэг. Төмөрлөгийн зүйлсийг урлан хийхэд цугтан хэвлэх, дахин хэвшүүлэх, тавлан гагнах, бидэрлэн сийлэх, сүлжин мушгих, шөөдхөн гүйлгэх зэрэг аргыг хэрэглэдэг. Ширэн эдлэл урлахад элдэх, идээлэх, зүсэх, оёх, тамах,

зангидах, хөрөх зэрэг аргыг хэрэглэдэг. Гар урлалын эдгээр олон зүйлийн урлан бүтээх арга барил нь уран зургийн бусад төрлийн илрүүлэх арга барилаас ангид ялгаварлагдаад гар урлалын илрүүлэх арга барилын олон талт шинжийг харуулжээ.

Тухайн үеийн гар урлалын төсөвлөн үйлдэх шат үе нь хоёр чухал онцлогтой байдаг. Нэг бол амьдралын орчин ахуй, арга хэлбэр болон үйлдвэрлэлийн хэр түвшний хязгаарлалаас болж, төсөвлөн хийсэн бүтээл нь голдуу дөхөм дөт амьдралын хэрэглэл байж, жишээлбэл, ваар сав, гэрийн хэрэглэл жич эл зүйлийн тоо хэмжээтэй бүдүүлэг хийцийн хөдөлмөрийн бааз хэрэгсэл байж, зохион үйлдэх арга хэлбэр нь голдуу хүмүүсийн гарын чадварт түшиглэдэг байснаас үйлдвэрлэгчид нь чөлөөтэй урлан бүтээх бололцоотой байв. Ийнхүү үйлдвэрлэж гаргасан олон янзын хэлбэр онцлогтой байдаг. Үүнд, засал чимэглэл нь бүтээгдэхүүний хэв онцлог ба үнэ цэнийг тогтоох гол арга барил болдог. Энэ нь одоогийн үйлдвэрлэлтэй адилгүй. Үйлдвэрлэх, борлуулах нь нэгэн цогц байснаас үүдэн үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид нь харилцан ойр байж, үйлдвэрлэгч нь хэрэглэгчийн хувь хүмүүний адил бус шаардлага хэрэгцээнд тохируулан итгэл найдвартай үйлдвэрлэдэг болохоор маш олон өвөрмөц хэв хэлбэрийн сонгодог бүтээгдэхүүн бий болсон байдаг.

Гар урлал бол “эд бодсын боловсны хэр хэмжээг тусгах мөртөө тогтсон хэмжээний үзэл ухамсрын хэлбэрийг илтгэдэг” (Сайн-Өлзий нар, 2003, х.542). Хүмүүн төрөлхтөн асга хадан дээр хадны зургийг зурж үлдээснээс нааш гар урлалын хэлбэрээр тухайн нийгмийн үйлдвэрлэлийн арга хэлбэр, үзэл ухамсрын хэлбэр, гоо сайхны үзлийг ухамсартай буюу ухамсаргүйгээр тусгасаар иржээ. Энэхүү үзэл ухамсрын хэлбэрээс бид тухайн үеийн хүмүүсийн шүтлэг бишрэл, зан үйл, хүсэл мөрөөдлийг тод томруунаар харж болно. Иймэрхүү жишээг бид түүхийн үе бүхэнд урлан бүтээсэн гар урлалын бүтээлээс хайн сүвэгчилж олдог. Хүннүгийн үед алтаар урлан хийсэн нэг зүйлийн титэм байв. Тэр титмийн алтан оройвчийг эрэлхэг харцгайгаар урлан хийсэн нь тухайн үеийн хүмүүс харцгай шувууг дээд амьтнаар үзэж шүтэж байсан нь мэдэгдэнэ. Монголчуудын зарим овог холбоо нь өөрийн овог холбоогоо дурсган тэмдэглэхдээ малгайн тавгаар нарыг төлөөлүүлэн, улаан залаагаар нь нарны цацрагийг төлөөлүүлэн хөндлөн оёсоор нь овгоо төлөөлүүлдэг заншил ч бий. Ойр үеэс монголчуудын орон барилга, хувцас засал, гэрийн чимэглэлд өлзий зангиа олон харагдах болж түүнээр урт насалж удаан жаргахын бэлгэ хүслээ илтгэдэг болжээ. Монголын сэцэн үгэнд “мандах төрийн малгай, бүтэх төрийн бүс” гэдэгчлэн монгол

үндэстний эд ба оюуны соёлын хөгжин сайжрахыг дагалдан одоо уламжлалт гар урлалын соёл уламжлалыг цаашид хөгжүүлэн бадруулахын дагуу шинэ агуулгыг нэмэн оруулж баялагжуулахын хамт хамгийн чухал нь монгол үндэстний эдгээр уламжлалт эд ба оюуны өв соёлоо өнөөдрийн соёл, сургалтын агуулгад оруулж, сургалтаар дамжуулан үр хойчдоо өвлүүлэн залгамжлуулах нь Монгол үндэстний үндэс угсааны хойшдын мандан хөгжихтэй холбогдох алс хэтийн чухал ажил болно. Энэ ажил нь нэн тэргүүнд орхигдож гээгдэж байгаа монгол үндэстний үнэт уламжлалт өв соёлоо уудлан гаргаж, судлан шинжилж, нээн дэлгэрүүлж хөгжүүлэх нь өнөөгийн тулгамдсан асуудал болж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны өгүүллийг бичсэний үндсэн дээр дараах хэд хэдэн дүгнэлтийг дэвшүүлж болохоор байна.

- Гар урлалын багаж хэрэгсэл төрөл бүрийн онцлогтой байхаас гадна нийт төрөлд ашигладаг шөвөг, хутга, хайч, алх мэт түгээмэл багажтай байсан нь монгол гар урлаачдын нийтлэг байдлын илрэл болой.
- Урчууд маань гар урлал хийж бүтээх багажаа хүртэл өөрөө хийдэг чадвартнууд байжээ. Чухамхүү өөрийн арга барилдаа тохирсон даацтай бүтээл төрөхөд тус дэм болдгоос гадна тухайн урлаачийн онцлог бүхий

давтагдашгүй ур хийц бүхий цор ганц бүтээл төрөх нэг үндэс болдог байжээ.

- Багаж хэрэгслээ өөрийн гарт ортлоо эзэмшиж сурна гэдэг бол мэргэшсэн байгаагийн гэрч хэмээн үзэж болохоор байна. Багажаа барьж, эзэмшиж сурсан урлаачаас уран гоёмсог, цэвэр цэмцгэр, жигдрэл сайхантай бүтээл төрдөг байжээ.
- Орчин үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлийн үр дүнд шинэ төрлийн материал шинэ арга технологи нэвтэрснээр ардын урлагийн дэвшилд ихээхэн түлхэц болж байна.

Ашигласан материал

- Батчулуун, Л. (1999). Монгол эсгий ширмэлийн урлаг. Улаанбаатар
- Гэвшээхүү, Д. (1970). Монгол ардын гар урлагийн уламжлалт арга. Улаанбаатар
- Урлаг зүй. Өвөр Монгол Ардын хэвлэлийн хороо, 1996.
- Лувсанвандан, С. (1982). Монголын урлагийн уламжлал шинэчлэл. Улсын хэвлэлийн хороо. Улаанбаатар
- Сайн-Өлзий, С.Отгонбаяр, Бай Ган, Самбалноров. (2003). Урлаг. Хөх хот: Өвөр Монгол Ардын хэвлэлийн хороо.
- Ядамжав, Ц. (2004). Монгол ардын гар урлал. Улаанбаатар.

Creative tradition of Mongolian handicrafts: Feature

Ba. Na Yin Tai

National Vocational High School of Etuokeqian Banner, Inner Mongolia

Abstract

Handcraft profession was originally developed since the existence of humans and their living in the world; progressed gradually and step-by-step; and came up to the present stage and it is one of the most important part of intellectual cultures that has not to be insufficient ever. Also, it has to be an expression of common culture which is spread to all of acts of human life and is sufficiently allotted the society as cultural and utilization needs. There is an example for Mongolian's past living styles: to live in Mongolian ger which is associated with pure nature, and there are a lot of crafts made by hardworking men such as wooden bowl (silver bowl), wooden luggie, wooden plate, wooden table, wooden seat, wooden saddle, wooden lasso, wooden basket and wooden cart which are helpful for them to live peaceful, to get benefit from their livestock and perform their everyday duties. The appearance of history of the craft culture of the ancient people's handcraft who settled on the Central Asian Highlands is connected to the age of paleolith.

Handcraft of ancient Mongolians directly dependent on climate, location, and nomadic animal husbandry. Crafts are divided into two types of consumer crafts and exquisite crafts. Mongolian handicraft materials are classified as animal, natural and metallic and precious materials. The following materials are used as handcraft:

Wood and stone will be engraved. Gold and silver have been casted. Wool felt and wire. Based on this, we can show that there are many different types of Mongolian handicrafts. Inner Mongolian Handicrafts are forgotten and Studying and developing Mongolian traditional culture is a major issue.

Key words

Handicraft, wood, stone, metallic, leather, culture, nomadic culture